

**"ХАРХОРИН" ХК-ИЙН 2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 26-НЫ ӨДРИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2025 оны 04-р сарын 26 өдөр

Хархорин сум

"Хархорин" нээлттэй хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2025 оны 04-р сарын 26-ний өдөр 14.00 цагаас Өвөрхангай аймаг, Хархорин сум, Эрдэнэтолгой баг, Усжуулах 00 хаягаар байрлах компанийн өөрийн байранд хурлын танхимд хуралдав.

Тус хурлыг "Хархорин" ХК-ийн ТУЗ-ийн 2025 оны 03-р сарын 17-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зарлан хуралдуулах тухай 02/2025 дугаар тогтоолын дагуу зарлан хуралдуулсан болно.

Хурал болсон газар: Өвөрхангай аймаг, Хархорин сум, Эрдэнэтолгой баг, Усжуулах 00 хаягаар байрлах компанийн өөрийн байр, 1 давхарт хурлын зааланд

Хурал болсон он, сар, өдөр, цаг: 2025 оны 04-р сарын 26-ний өдөр 14.00 цагаас

Хурлын даргын эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр: Пүрэвийн Учрал

Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчид:

"Хархорин" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 04-р сарын 26-ний өдрийн ээлжит хуралд хувьцаа эзэмшигч Цэндсүрэнгийн Баасансүрэн (100 ш хувьцаатай), Чимэддоржийн Отгонсүрэн (93 ш хувьцаатай), Цэвээний Бүрэнжаргал (93 ш хувьцаатай), Лхамсүрэнгийн Энхтуяа (70 ш хувьцаатай), Сүрэнжавын Пүрэв (377,660 ш хувьцаатай), Долгорсүрэнгийн Дашмаа (100 ш хувьцаатай) нар оролцсон болно. Хурал хуралдсан өдрийн байдлаар саналаа өөрийн үйлчлүүлдэг брокер дилерийн компаниар дамжуулан өгсөн хувьцаа эзэмшигч бүртгэгдээгүй болно. Тус хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн саналын эрх бүхий хувьцааны нийт тоо 378,116 ширхэг буюу 70.08%

Хурлаар байлцсан бусад хүмүүс: Түүнчлэн тус хурал дээр компанийн гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч бөгөөд ТУЗ-ийн гишүүн П.Учрал хурлын даргалагчаар, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга бөгөөд хурал зохион байгуулах комиссын дарга Б.Ганбат хурлын тэмдэглэлийг үйлдэж, тооллогын комиссын дарга М.Шавагцэрэн, тооллогын комиссын гишүүн Ц.Болортуяа, ерөнхий агрономич Л.Бямбасүрэн, нярав М.Оюунбилэг, ажилчид Б.Уранчимэг, Л.Алтанцэцэг нар байлцсан. ТУЗ-ийн хараат бус гишүүн С.Амгалан, Б.Бүрэн нар харилцаа холбооны хэрэгсэл ашиглан зайнаас оролцсон. ТУЗ-ийн хараат бус гишүүн Б.Амарсанаа хүрэлцэн ирж оролцохоор байсан боловч хүндэтгэн үзэх шалтгаанаар тус хуралд оролцоогүй.

Хурлын тэмдэглэл хөтөлсөн: Хурал зохион байгуулах комиссын дарга Б.Ганбат

Хурлын ирц: 70.08 хувь

Хувьцаа эзэмшигчдийн саналын эрхийн тоо болон хурлын ирцийн тухай:

Тус хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг бүртгэлийн өдөр болох 2025 оны 04-р сарын 07-ны өдрөөр тасалбар болгон "Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" ХХК-с гаргуулсан хувьцаа эзэмшигчдийн дэлгэрэнгүй болон хураангуй судалгаанд

үндэслэн зохион байгуулсан. “Хархорин” ХК-ийн 2025 оны 04-р сарын 26-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий нийт 586 хувьцаа эзэмшигч иргэн, хуулийн этгээд бүртгэлтэй байгаагаас тус хуралд нийт 378,116 ш энгийн хувьцаа эзэмшиж байгаа 6 хувьцаа эзэмшигч хуралд оролцож саналаа өгсөн. Өөсдийн үйлчлүүлдэг брокер дилерийн компаниар дамжуулж саналаа өгсөн хувьцаа эзэмшигч байхгүй. Мөн баталгаат шуудан, хурал зохион байгуулах комиссоор дамжуулж саналаа өгсөн хувьцаа эзэмшигч байхгүй. Итгэмжлэлээр төлөөлж тус хуралд оролцсон хувьцаа эзэмшигч бүртгэгдээгүй болно. Хурлын ирц 70.08% болсон. Ирцийн тайлан дараах байдалтай байна:

д.д	Хуралд оролцсон, саналаа хэрхэн өгсөн	Хувьцаа эзэмшигчийн тоо	Хувьцааны тоо
1	Хуралд өөрийн биеэр хүрэлцэн ирж оролцсон	6	378,116 (70.08%)
2	Хуралд биечлэн оролцоогүй, саналаа саналын хуудсаар ирүүлсэн	0	0 (0%)
	Нийт	6	378,116 (70.08%)

Хурлыг Монгол Улсын Компанийн тухай хууль, Компанийн дүрэм, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 377 тоот тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын дагуу зарлан хуралдуулсан.

Тус хурлыг зарлан хуралдуулах тухай шийдвэрийг компанийн Төлөөлөн удирдах зөвлөл 2025 оны 03-р сарын 17-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зарлан хуралдуулах тухай 02/2025 дугаар тогтоолоор гаргасан. Хурлын мэдэгдлийг тогтоосон хугацаанд Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид тус тус хүргүүлсэн. Мөн хурлын мэдэгдлийг МХБ-ийн цахим хуудсан дээрх “Хархорин” ХК-ийн мэдээлэл хэсэгт байршуулсан.

Хурлаар хэлэлцсэн асуудал:

1. Компанийн 2024 оны жилийн үйл ажиллагааны талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах.
2. Компанийн 2024 оны жилийн санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах.
3. Ногдол ашиг хуваарилахгүй тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан шийдвэрийг батлах.

Саналын хуудас хэрэглэсэн эсэх, саналын хуудасны загвар: “Хархорин” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 03-р сарын 17-ны өдрийн 02/2025 дугаар тогтоолын хавсралтаар компанийн хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 04-р сарын 26-ны өдрийн ээлжит хуралд хэрэглэх саналын хуудасны загварыг баталсан. Санал хураалтыг тус батлагдсан саналын хуудсаар явуулсан болно (Компанийн тухай хуулийн 71.1-ийн дагуу).

Хурлын явц

Тооллогын комиссын зүгээс хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчдийг бүртгэж, хурлын ирцийг мэдээлснээр хурал эхэлсэн болно.

Хурлын даргалагч хурлыг нээж үг хэлсэн бөгөөд хурлын дэгийн төслийг танилцуулав (хурлын тэмдэглэлд хавсаргав).

Хурлын дэгийн төслийг хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчид санал нэгтэй бүгд гараа өргөж зөвшөөрсөн болно. Ингээд хурлын дарга хурлаар хэлэцэх асуудлуудыг уншиж танилцуулав.

1-р асуудал болох 2024 оны үйл ажиллагааны талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг ерөнхий агрономич Л.Бямбасүрэн уншиж танилцуулсан болно
(тайланг хурлын 1-р тогтоолд хавсаргав)

1-р асуудлаар хувьцаа эзэмшигчдийн үгээс гаргасан санал, асуулт, шүүмжлэл: тухайн асуудлаар хуралд оролцогчдын зүгээс ямар нэгэн санал, шүүмжлэл, асуулт гараагүй болно.

2 болон 3-р асуудлууд болох 2024 оны санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлт, 2024 оны үйл ажиллагаанаас ногдол ашиг хуваарилахгүй тухай ТУЗ-ийн шийдвэрийн тухай ерөнхий нягтлан бодогч Д.Дашмаа уншиж танилцуулсан болно
(тайлан болон ногдол ашиг хуваариалхгүй тухай ТУЗ-ийн тогтоолыг хурлын 1-р тогтоолд тус тус хавсаргав)

2 болон 3-р асуудлуудаар хувьцаа эзэмшигчдийн үгээс гаргасан санал, асуулт, шүүмжлэл:

Хувьцаа эзэмшигч Баасансүрэн: жил болгон хурлаа хийх юм, зөндөө тайлбар, тайлан тооцоо, тоонууд танилцуулж байна. Гэхдээ хувьцаа эзэмшигч бидний хувьд компаниасаа ногдол ашгаа авах хүсэлтэй байна. Тайлбар өгнө үү.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Ганбат: Таны энэ асуудлыг хувьцаа эзэмшигч болгон тавьдаг. Компани ямар нөхцөлд ногдол ашиг хуваарилж болох талаар Компанийн тухай хуульд заасан байдаг. Хэрвээ тухайн тайлант жилд компани ашигтай ажилласан бол ашгаасаа ногдол ашиг хуваарилах журамтай. Гэтэл жил дараалан алдагдалтай ажилласан, 2024 онд мөн алдагдалтай. Иймд хуулиараа ногдол ашиг хуваарилах боломжгүй байна.

Хурлаар шийдвэрлэсэн асуудал тус бүрээр зөвшөөрсөн, татгалзсан, түдгэлзсэн саналын тоо, гаргасан шийдвэрийн бүрэн томъёолол:

Асуудал 1: Компанийн 2024 оны жилийн үйл ажиллагааны талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай

1-р асуудлаар зөвшөөрсөн саналын тоо: 378,116; татгалзсан саналын тоо: 0; түдгэлзсэн саналын тоо: 0. Хүчингүй саналын хуудас гараагүй болно.

1-р асуудлаар гаргасан шийдвэрийн бүрэн томъёолол: "Хархорин" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 04-р сарын 26-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9-г удирдлага болгож компанийн 2024 оны жилийн үйл ажиллагааны талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг хангалттай гэж үзсэн болно.

Асуудал 2: Компанийн 2024 оны жилийн санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай

2-р асуудлаар зөвшөөрсөн саналын тоо: 378,116; татгалзсан саналын тоо: 0; түдгэлзсэн саналын тоо: 0. Хүчингүй саналын хуудас гараагүй болно.

2-р асуудлаар гаргасан шийдвэрийн бүрэн томъёолол: "Хархорин" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 04-р сарын 26-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9-г удирдлага болгож компанийн 2024 оны жилийн санхүүгийн тайлангийн тухай Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг хангалттай гэж үзсэн болно.

Асуудал 3: Ногдол ашиг хуваарилахгүй тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан шийдвэрийг батлах тухай

3-р асуудлаар зөвшөөрсөн саналын тоо: 378,116; татгалзсан саналын тоо: 0; түдгэлзсэн саналын тоо: 0. Хүчингүй саналын хуудас гараагүй болно.

3-р асуудлаар гаргасан шийдвэрийн бүрэн томъёолол: "Хархорин" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 02-р сарын 18-ны өдрийн 01/2025 тоот тогтоол, Хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 04-р сарын 26-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын шийдвэрийг тус тус үндэслэн, Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.6-г удирдлага болгоод "Хархорин" Нээлттэй Хувьцаат Компани нь 2024 оны жилийн эцсийн аудитлагдсан санхүүгийн тайлангийн дагуу нийт 349,874.8 мянган төгрөгийн татварын дараах алдагдалтай ажилласантай холбогдуулан 2024 оны үйл ажиллагаанаас ногдол ашиг хуваарилахгүй тухай Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан шийдвэрийг зөвшөөрөв.

Бусад асуудал хэлэлцсэн эсэх: Тус хурлаар бусад асуудал хэлэлцээгүй болно.

Хурал өндөрлөсөн: 15.40 цагт хурал өндөрлөсөн болно.

Хурлаар шийдвэрлэсэн нь:

"Хархорин" нээлттэй хувьцаат компанийн 2025 оны 04-р сарын 26-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаас дараах шийдвэрүүдийг гаргасан болно. Үүнд:

1. "Хархорин" Нээлттэй Хувьцаат Компанийн 2024 оны жилийн үйл ажиллагааны талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг хангалттай гэж шийдвэрлэв.
2. "Хархорин" Нээлттэй Хувьцаат Компанийн 2024 оны жилийн санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг хангалттай гэж шийдвэрлэв.
3. "Хархорин" Нээлттэй Хувьцаат Компани нь 2024 оны жилийн эцсийн аудитлагдсан санхүүгийн тайлангийн дагуу нийт 349,874.8 мянган төгрөгийн татварын дараах алдагдалтай ажилласантай холбогдуулан 2024 оны үйл ажиллагаанаас ногдол ашиг хуваарилахгүй тухай Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 02 дугаар 18-ний өдрийн хурлаас гарсан шийдвэрийг зөвшөөрөв.

ХУРЛЫН ДАРГА

Хурлын тэмдэглэл үйлдсэн



П.УЧРАЛ

Б.Ганбат